



## УНШИХУЙН АРАНШИН ХИЙГЭЭД УНШИХУЙН МЭДРЭМЖ ...

(Үг зүйвэл учиг болдог, учиг гүйцвэл утга болдог)

### Abstract:

*The mistaken strategies of reading versus the sense of reading*

*This article is based on the practical experience of teaching Academic English Reading Course for the first- and second-year psychology and social work students at School of Educational Studies of Mongolian State University of Education. Most freshmen and sophomores admitted to the school adopt several mistaken strategies (habits) to read, understand and perform text-based tasks. The most frequent common denominator of these strategies (habits) is that they seem to be symptomatic of a lack of confidence, resulting from poorly developed skills gained at secondary schools. At the same time, skills that students have are often not appropriately applied because of a fear of the English text. This article describes a few mistaken strategies (the character of reading) - «уншихуйн араншин», explains the cause or causes of such approaches, suggests some possible didactic solutions each of which assures the sense of reading - «уншихуйн мэдрэмж», provides example activities for achieving each of the solutions. Teachers can better assist students if they are aware of these mistaken approaches and their causes. Only after such awareness can they help students acquire tools for improving their mistaken strategies - tools for making sense of reading - what activities (reading in sense groups; collocational notetaking; having concepts and condensing them in the students' vernacular; summarizing in the students' vernacular; summarizing in the target language; rendering the whole passage in the students' vernacular) we have designed and introduced for a tertiary level foreign language classroom.*

Түлхүүр ойлголтууд: **уншихуйн араншин** - “үг цээжинд, утга цоожинд”; “үгэнд цэг тавих, утганд тэг тавих”; “үг тогтох атал, утга урагдах мэт”; “үг цээжлэх атал утга сийчих мэт”; “саланги үг санаа хоосон”; “дан үг даржин хоосон”; “үгийг орчуулах атал, утгыг оршуулах мэт”; товчлох гээд “огтлох”; “хураах гээд нураах”; “орчуулга биш оршуулга болох”; хураангуй биш “нураангуй” болох; хайран юм



**МУБИС-ийн Гадаад хэлний сургуулийн Англи хэл, Америк судлалын тэнхимийн ахлах багш Ц.Даваабаяр**

(бичвэр) яайран (цээжлэх) болох; “олдохоор өлдөх”; “гахай нүцгэн нохой явган хоцрох”; **уншихуйн мэдрэмж**: уншуулбар; уншихаа мэдрэх (аялга дуудлагын мэдрэмж-Я.Хишигт); учиг учигээр утга мэдрэх (үг-утгын мэдрэмж-Я.Хишигт); үг зүйвэл учиг болдог, нэхий зүйвэл дээл болдог, үгэнд толь хөтлөнө, утганд учиг хөтлөнө, хэлзүйн бүтэц-байгууламжаа мэдрэх (дүрэм-найруулгын мэдрэмж-Я.Хишигт); санааг нь мэдрэх; санаатай болох; санаагаа эх хэлээр хураангуйлах; санаандаа хэл оруулах;

Бид өмнөх өгүүлэлдээ (ГХЗАА асуудал сэтгүүл, №21, 2009 он, 51-55 тал; “Оюуны хөтөч”, №4, 2009, 57-64 дэх тал;) их, дээд сургуулиар олгож байгаа **гадаад хэлний боловсролын хүртээмжийн** тухай асуудал хөндөж, агуулгын хувьд тогтвортой, суралцагчдын эрэлт, хэрэгцээнд илүү хальдамжтай, тэдний мэргэжлийн чиглэл, сонирхол, сургалтын шатлал, зэрэглэл, түвшинг харгалзсан, судалж байгаа хэлнийхээ өгүүлбэрзүйн

байгууламжийн хийгээд үгийн сангийн давтамж, хэлзүйн уялдааг гүйцсэн **сунган уншуулах** хэд хэдэн хувилбар сургалтын хэрэглэгдэхүүн (эх бичвэр) боловсруулан сургалтад нэвтрүүлж байгаа зарим санаагаа уншигч та бүхний сонорт толилуулж, харин заах аргагүйн нарийн ширийн асуудлаа дараа жич ярилцахаар авч үлдсэн билээ. Тэгээд аргагүйн шинжтэй гэж хэлж байгаа энэхүү асуудлаа манай дунд сургуульд ажиллаж байгаа багш нарын гар дээрээс тус их сургуулийн сэтгэл судлал, нийгмийн ажил, боловсрол судлал, салбарын дидактикийн чиглэлээр элсэгч - оюутан (бакалавр), түүнчилэн оюунтан (магистр), горилоч (докторант) нарын гадаад хэлээр, тухайлбал англи, орос хэлээр юуны өмнө уншлага үйлдэж байгаа зарим арга барил, тэдний ой ухаанд суусан хэвшмэл сэтгэлгээ, зуршмал арга барил, дадал хэвшил зэргээс анзаарагдаж байгаа зарим ажиглалт, тэдний дунд явуулсан ярилцлага, тодруулга, өдөр тутмын хичээлийн тэмдэглэл зэрэгтээ тулгуурлан “шүүмжилж” биш, харин “шүүж” үзье гэвэл, ер нь яасан юм гэж бодлоо доо. Манай үндэсний эрдэмтдийн (Б.Пүрэв-Очир, Ц.Базаррагчаа, О.Адьяа, Я.Хишигт, Д.Циеэрэгзэн, З.Гулираанз, Я.Хишигт, Д.Нямжав, Д.Батчулуун, Х.Цэдэв, Б.Дэмэд, З.Ганчимэг, Д.Алтанцэцэг зэрэг) хийгээд сүүлийн үеийн судлаачдын (Ц.Даваабаяр, М.Даариймаа, Ц.Энхмаа, Ц.Цэцэгмаа, Н.Амаржаргал зэрэг...) судалгаа-шинжилгээний ажлын үлэмж хэсэг **эх бичвэр, дискурс, корпус** зэрэг хэлнийн томсгосон, **шүтэлцэн багцарсан** (Б.Жадамба, УБ, 2008) дидактик нэгжүүдийн сургахзүйн боломжийг илрүүлэн ашиглах, дайчилах, татан төвлөрүүлэх замаар гадаад хэлний сургалтын үйл явцыг аль болох **эрчимжүүлэх** (Я.Хишигт.1999), **идэвхжүүлэх** (Д.Нямжав.2002), **агуулга**



**хүртээмжийг дээшлүүлэх** (Ц.Даваабаяр.2009)-д түлхүү чиглэгдэж иржээ. Эх бичвэр, дискурс, корпус зэрэг хэлний дээд түвшингийн томссон, багцарсан нэгжүүд нь эх хэл, соёлын орчин, хүрээлэлд гадаад **хэлний оролт** (finely tuned input and roughly tuned input by S.Krashen, 1982)-ыг хамгийн ихээр ханган нийлүүлж байдаг сургалтын үндсэн эх сурвалж гэдэгт үндэсний судлаачдын үзэл хандлага үндсэндээ нэг чигт байгааг ч бас давхар харуулж байгаа юм. Үзэл хандлага хэдүй нэгдмэл байгаа ч, эх бичвэрийг зөвхөн хэлзүйн дүрэм таниулах, үгийн сангийн дасгал төдийд ашиглах, аль эсвэл уншсанаа тогтоож ярих, дүн үнэлгээ авах/тооцох зэрэг цөөхөн тохиолдолд л манай аль ч шатны сургуулийн гадаад хэлний сургалтад түгээмэл ашиглаж байгаа нь дээр дурдагдсан болон, бас эс дурдагдсан үндэсний судлаачдын бүтээл туурвилаас ч, бидний сургалтын ажлын өдөр тутмын практикаас ч тодорхой ажиглагдаж байна. Энэ нь сургалтын нэн түгээмэл хэрэглэгдэхүүн болох эх бичвэрийн сургахзүйн боломжийг, нэг талаас дутуу дулим ашиглаж байгаа, нөгөө талаас бүтээлч сэтгэлгээ, арга барилаар үйлчлүүлж байгаа хүмүүсийнхээ бодот хэрэглээтэй нийцүүлэн өөрийн **гарт ортол** боловсруулахгүйгээр, гадаадын сурах бичиг, гадаад хүний оролцоотой, тэдний өөрийн эх орондоо сургалт явуулж байгаа орчин нөхцөлд нэн тохиромжтой байсан болгоныг, бидний гадаад хэлний сургалт явуулж байгаа эх хэл, соёлын орчин, хүрээлэлд нэг талаас **“хүртээмжгүй”** байдаг гэдгийг даанч гүйцэд ухаарахгүй, нөгөө талаас **“хэрэглээгээ танихгүй”** хэтрүүлж хэрэглэдэгээсээ болоод хэв нэг бэлэнчлэх хандлагатай байна гэж бидний, арай ч хатуудаж байгаа гэмээр дүгнэлт хийсэн маань үнэний ортой байжээ гэдгийг ч бас давхар харуулж байгаа хэрэг. Иймээс эх бичвэрийн сургахзүйн боломжийг дээшлүүлэх асуудлаар үндэсний эрдэмтэд, судлаачдын зүгээс өгч байгаа дүгнэлт, дэвшүүлж байгаа үнэтэй санал, зүй ёсны сануулга, анхааруулга бол ерөнхий боловсролын төдийгүй, мэргэжих болон мэргэших салбарын гадаад хэлний боловсрол эзэмшүүлдэг их, дээд сургуулиудад ч зайлшгүй тусгаж хэрэгжүүлэх сургалтын зүй ёсны шаардлага болон тавигдаж байна. Бид үндэсний эрдэмтэд, судлаачдын эдгээр санал, дүгнэлтийг аль болох тусган ажиллахыг хичээж байгаа бөгөөд эх, бичвэрийн сургахзүйн боломж багшийн гар дээр, хичээлийн

танхимд, тодорхой мэргэжлийн анги бүлэгт, тухайлбал, тус их сургуулийн сэтгэл судлал, нийгмийн ажлын салбарт элсэн суралцагчдын мэргэжих салбарын Англи хэлний хичээлээр ордог бичвэр дээр уншлага үйлдэж байгаа техник, бичвэрийн доторх хэлэхүйн уялдаа, сүлжээн дээр ажиллаж байгаагаас нь ажиг байж ажлаа эхэлье гэх, алжаал зүдэргээг нь анзаарч байж арга барилаа олъё гэх, алгуур аажим боловч ахиц амжилт өөд дагуулья гэх жирийн багшийн гар дээр хэрэглээгээ хэр олж тусч байгаатай жин дүйлгэж, жишиж нэг үзье л гэсэн юм.

Тус их сургуульд хэлний бус салбар, мэргэжлээр төв, аймаг, орон нутгаас элсэгчдийн дийлэнх хэсгийн дунд эх бичвэр ойлгох битгий хэл, бүр “умшихдаа” маруу, “умшлага” үйлдэх наад захын техник, дадал, чадвар хангалтгүй суусан байдал нийтлэг анзаарагдах юм. Уншихдаа ээ, мөн ч их түүртэх юм. Суралцагчдын уншлага үйлдэх үеийн хэлэхүйн **араншинг** тодорхойлж байгаа гэж болох “таван төрлийн түүртэл” анзаарагдаж байгааг тав гурван үгээр хөгжөөж, уншигч авхай нарынхаа хорхойг хөдөлгөвөл ер нь яасан юм бэ.



## Уншихуйн араншин:

**1)** Уншиж байгаа эх бичвэрийн ая хөг, айзам хэмнэл, логик өргөлт дуудлагад авах юм үгүй шахуу л **айхтар их түүртэх** юм. Үг үгээр салгаж, саланги саланги дууддаг хэв нэг загвар хээ хаагаа алдаж, хэвшил зуршил болсон шиг байна. Уншихуйн энэ араншинг ер нь ингэж дуудвал яадаг юм бэ? Үе үеэр үелж шахуу уншина, үг нь харин үгүй болохдоо хүрнэ. Үг үгээр тасалж уншина, өгүүлбэр ч бас үгүй болохдоо хүрнэ. Ганц ганцаар дуудна, газрын нэг тараана. Хаа хамаагүй халдана, хаагуур ч хамаагүй уншина. Хажуу үгнээс халгана, хамт дуудахаас халширна. Хөрш үгнээс жийрхэнэ, хөглөн уншихаас хөндийрнэ. Салгаж дуудахаар санаа амарна, нийлүүлж дуудахаас санаа зовно. Эмээж уншина, эндүүрч дуудна. Сандарч уншина, салгаж дуудна. Айж уншина, андуурч дуудна. Арын үгийг амдана, аяыг олох гэж ядна. Өөрөө ч мэдэхгүй өргөж нэг дуудна, даанч мэдэхгүй дарж нэг дуудна. Дайруулж нэг үг дуудна, дагуулж хоёр үг дуудна. Дуугүй хоёр үг уншина, дуутай гурван үг уншина. Ингэж

тэгж уншсаар явтал өмнөх үгийн **хөг** нь өнгөрнө, арын үгийн айзам алдарна. Хөөрхий үгс хөгөө алдана, хөөрхий хүүхдүүд **хөгөө** тарина. Адгаж уншина, айзам алдарна. Уншиж байгаа нь дуулдана, ойлгож байгаа нь туйлдана. Юу ч хамаагүй уншина, юу ч эс ойлгоно. Уншихаа мэдэхгүй нэг уншина, ойлгож байгаагаа мэдэхгүй бас нэг уншина. Уншихаа мэдэхгүй хөглөнө, зүгээ олохгүй зөнөнө. Ийм нэгэн араншинд уншигч болгон шахуу автсан ирэх юм. Энэ түүртэл бидний л анзаарснаар, үнэхээр “амь бөх”, “арга авахдаа” ч тийм ч амар биш дэг ээ.

**2)** Үгийн утганд **үгүй мөн ч их түүртэх** юм. Үгийг цээжинд ортол тогтоодог, утгыг уланд ортол гишгэдэг ийм нэгэн дутагдалд олноороо ч орсон шиг байна. Суралцагчид үг тогтоомхой, утга дайжимхай болсон байх юм. Уншихуйн иймэрхүү араншинг ингэж тоймнож бас болох юм? Үгэнд уулга алдана, утганд туулга алдана. Үгэнд уусна, утганд дөжирнө. Үгэнд баригдана, утганд балартана. Үг салгамхай, утга залгимхай. Үгэнд яг хөдөлнө, утганд таг хөдөлнө. Үгэнд булиа, утганд будлиу. Үг тольдомтгой утга ташаарамтгай. Үг тогтомхой, утга цуцамхай. Үгэнд ухасхийх, утганд гэдэсхийх. Үг наана үзэгдэнэ, утга цаана хоцорно. Үгийг үргээнэ, утгыг унтраана. Үг дээрээ хөвөрнө, утга



доороо хөглөрнө. Үг нь харагдана, утга нь дарагдана. Үг гүйлдэнэ, утга туйлдана. Үгийн наагуур өнгөрнө, утгын цаагуур өнгөрнө. Үгийн үдээ гаднаа, утгын уяа дотроо. Үг майд, утга сүйд. Үг үдээтэй үлдэнэ, утга уяатай хоцорно. Үг яг, утга таг. Үг цээжинд утга цоожинд. Үг тодорно, утга бүдгэрнэ. Үгэнд цэг тавина, утганд тэг тавина. Үгийг орчуулна, утгыг оршуулна. Үг болгоноор хөөцөлдөж үгийн утга үгүй хийдэг. Үг залгамхай, утга салгамхай. Дан үг даржин хоосон саланга үг санаа хоосон. Үгэнд "толь" хөтлөнө, утганд "тэг" хөтөлнө. Үг нүдэнд тусна, утга уланд гишгэгдэнэ. Үгэнд үгүй мөн дөтөрхөнө, утганд үгүй мөн шүжирнэ. Үг олноо утга холдоно. Үг үрэгдэнэ, утга урагдана. Мэдэх үг бараг үгүй, мэдрэх утга бүр ч үгүй. Үзсэн үг олон ч үгийн сан ядмаг. Суралцагчдаар бичвэр уншуулж байхад тэд мэдэхгүй, ойлгоогүй санагдсан үг болгоноо голдуу багшаас асуух, эсвэл бусдын ам харах, аялдах, аль эсвэл юм л бол толь бичгээс л лавлах, харах гэдэг. Суралцагчдаар бие даасан ажил хийлгэнэ гэж уншиж орчуулах, шинэ үгийн толь хийх даалгавар бид өгдөг биз. Харин тэдний хийсэн "шинэ үгийн гэх тол"-ийг үзвэл, нөгөө л дан дан, салангид салангид үгэнд, ёстой л, "толь бичигтэйгээ жигтэйхэн адилхан толь" хийсэн байдаг. "Толь" үзүүлж тов хийсэн дүн ч тооцуулно. Гэтэл суралцагчид бичвэрээ уншиж ойлгох байтугай, бараг уншсан ч юм уу, үгүй ч юмуу гэмээр ойлгомжгүй байдалд багшийг оруулж баллаж тавих юм. Тэд шинэ үг мэдэх сурах гэхээсээ илүү, мэддэг байх, мэдсэн байх ёстой шахуу үгээ ч жагсааж бичээд толь хараад л тавьсан голдуу ирэх юм. Амаар асуухаар хариулахгүй, харин харж байгаад уншина, ётсой л асуухад харам, хариулахад хэцүү гэдэг л болох юм. Иймээс энэ толь нь бичвэрээ унших, ойлгох шаардлагагүй шахуу байдалд суралцагчдыг оруулаад байдаг юм биш биз гэж ч санагдах юм. Үг зүйж утга олох гэж түүртэж суухаар, харин мэддэг мэддэггүй, ойлгосон ойлгоогүй шинэ хуучин хэдэн үг жагсааж бичээд, бүр тогтоох ч үгүй дүн үнэлгээ тооцуулаад байдаг хөнгөн хялбар арга барилд зуршиж, бичвэрийн хэлд орох байтугай, бүр бичвэрийн хэлнээс дайжиж дарвидаг араншинд яах ч аргагүй автдаг бололтой юм.

**3) Хэлзүйн байгууламжид хэт их түүртэх юм.** Өгүүлбэр нэг төрлийн хэд хэдэн гишүүнээр, аль эсвэл, хэд хэдэн гишүүн өгүүлбэрээр дэлгэрч зузаарахын хэрээр өгүүлбэр уртдаж ирдэг байна. Өгүүлбэр уртадсанаас хэлзүйн бүтэц-байгууламж, хэлзүйн дүрэм-журам, хэл-найруулгын учрыг танихгүй тэвдэнэ, хэлийг нь мэдэхгүй мэгдэнэ. Санааг нь гүйцэхгүй сандарна, хэлийг нь гүйцэхгүй хэцүүдэнэ. Хэлзүйн хэлбэрээ эхтэрхий их танина, хэлэгдэж байгаа санааг нь хэтэрхий их ташаарна. Хэлзүй нь хэв нэг хэрхэнэ, санаа нь харин сарниж сатаарна. Сэжгээр өвдөнө, сүжгээр эдгэнэ гэдэг дээ. Үүнд л сүжиг хүртээж, ёстой л шүншиглэх хэрэг байгаа юм.

**4) "Санаа"-тай холбоотой дөрөв дэх төрлийн түүртэл байна.** Санааг нь олохгүй самуурдгаас энэ төрлийн түүртэл гарч байх шиг байна. Санаагаа олох гэж, ёстой л, **салам** түүртэх юм. Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүд, гишүүн өгүүлбэр хоёрын **уртад** түүртэж явсаар ийм төрлийн араншинд яах аргагүй "автдаг" юм шиг байна. Санаа тээж, учиг шингээх дайны үгийн сангийн нэгж дээр ажиллуулж байгаагүйн балаг энэ юм даа. Үүнийг ер нь ингэж хэлээд үзвэл яадаг юм бэ? Дан үг дагаж даржин хоосон хоцорно, саланги үгэнд санаархаж санаа хоосон хоцорно. Иймээс санаа нь самуурч, сэтгэл нь сэглэрч хоцордог юм шиг байна. Хэлэгдэж байгаа санаанд нь биш, хэлж байгаа үгэнд нь баригдах, үг үгэнд баригдаж утга санааг нь үгүй хийдэг бололтой дог. Харж байгаа мэдээлэлдээ хамаг найдварсаа тавих атал хавьгүй

их хэрэг болох хур мэдлэг, хураасан түршлага хоёроо татан төвлөрүүлж сураагүй даанч доожоогүй нэг аргатай байгаагаас доройтож уруудах нь энүүхэнд байдаг ч юм уу. Уншаад **"санаа"** - тай болох биш, харин ч уншиж уншиж, бүр **"занаа"**-тай болох нь, ёстой л, **"замаа ч алдаж"** байна уу. Дэвсгэр мэдлэг нь дэнтэй дунтай, дэнслэх санаа нь оронтой гарантай, санаа нь **"сад тавиад"** байхад яаж сайн ойлгосон байж таарах вэ.

**5) Тав дахь түүртэл бол уншиж байгаа бичвэрээс орж ирж байгаа "хэлний оролт" ("Language Input" by Krashen S.) бичвэр уншсаны дараагаас хэл болж гарч байгаа "хэлний гаралт" ("Language Output" by Krashen S.) хоёрын тэнцвэр олодохгүй, оновчтой биш байгаатай холбоотой юм.** "Хэлнийхээ оролт"-д "орон алдан" түүртэх юм, "хэлнийхээ гаралт"-д "гаран алдан" түүртэх юм. Уншсан болгоноо эргүүлж ярих, цээжилж тогтоох гэж түүртдэг тоогүй хандлага, таагүй араншин, ёстой л, "талын нэг" таржээ. Хэлний оролт "гүд гүйж", гаралт "гаж" боловсрохыг ер нь ингэж дүйлгэвэл болох ч юм шиг: **товчилж** бичих гээд **огтолж бичих**", хурааж бичих гээд **"нурааж"** бичих, **орчуулж** хэлж бичих гээд **"оршуулж"** хэлж бичих, **"хайран"** юмыг (эх бичвэр) **"айран"** (цээжлэх) болгох. Харин юу ярьж байгаагаа мэдэхгүй мөртлөө яриад байдаг, уншсанаа ойлгож амжаагүй байдаг учраас л өөрийн эрхгүй цээжилж тогтоодог бололтой юм. Нэгэнт ойлгоц дутуу байдгаас уншиж ойлгосныг идэвхжүүлж байдаг хэлэлцүүлэг, мэтгэлцээн зэрэг "хэлний гаралт", хэрэглээ шаардсан өндөр үр дүнтэй арга, техникийг ашиглах бололцоогүй болгоход хүргэж байна. Гадаад хэл суралцагчдын ойлгоц шалгадаг Тийм/ Тийм биш, Үнэн/ Худал зэрэг сургалтын уламжлал арга таах, гөрдөх магадлал өндөр байдгаас "бингодох" зэрэг нэн таагүй арга техникт суралцагчдыг автуулж байдаг аж. Ийнхүү сургалтын шинжтэй гологдол, түгээмэл түүртлүүд ажиглагдаж байгаа нь гадаад хэлээр уншуулан харилцуулж сургах үйл ажиллагааны үндсэн шинж, **нэг зоосны хоёр тал** болсон унших **хурд, ойлгоцыг** (speed and comprehension like the two sides of a coin) бараг үгүй шахам хийж ирсэн юм биш биз гэж эргэлзэхэд ч өөрийн эрхгүй хүргэж байна. Энэ нь багш, сургагчдын зүгээс аливаа сургалт нь **сургах үйл явц, сургалтын үр дүн** гэсэн түгээмэл хоёр зүй тогтлын тэнцвэрт харилцаанд суурилсан байх зарчмыг алдагдуулж ирсний гай балаг гэхээс өөр юу гэх вэ. Зөвхөн сургалтын үр дүнг шүүд шахуу нэхсэн, нэг үгээр хэлбэл, унших үйл явцыг огт удирдлага, жолоодлого үгүй шахам орхиж, "хар аянд" нь хаяж, "эзэнгүй шахуу энгээр нь тавьж, эндүүр тэндүүр нь аргацааж ирсэн" явдал байгаа юм. Суралцагчдаас зөвхөн үр дүнг яаран шаардах болсноос, унших арга барилд сургах үйл явц доголдож, ёстой л **"хайран юм** (эх бичвэр) **айран** (цээжлэх)" болдог. Унших үйл явц хар аяндаа явагдах мэтээр бодож, буцаан яриулж байж л санаа нь амрах гэснээс унших арга барил, техник эзэмшээгүй, ойлгоогүй мөртлөө ойлгосон мэт харагдах гэж шавь болгон шахуу цээжлэн тогтоож, бас хүн хүний тоогоор шахуу яриулж тооцдог явдал, ёстой л, тоогоо алдаж, **"олдохоор өлдөх"**, арай ч **"гахай нүцгэн нохой явган"** гэгчийн үлгэрээр орж байгаа биш байлгүй дээ. Уншуулах техникт сургахгүйгээр, зөвхөн уншсаныг нь яриулах, тогтоолгох, цээжлүүлэх гэдэг сургалтад байж болох хэвийн хэмжээнээсээ арай ч хэтэрч байгаа бололтой. **Уншуулж сургах** гэж уншуулж байгаа хэрэг огт биш, харин **үг бичвэрийн дайны хэлэнд оруулах** гэж уншуулж байгаа хэрэг шүү дээ. Гэтэл хэдэн үг эргүүлж хэлсэн болоод бичвэрийн хэлд орохгүй, тэрхүү хэлийг нь сургаа ч үгүй, заагаа ч үгүй шахуу ард нь сууж, ёстой л бултаж, үлдээд байгаа хэрэг арай



биш биз. Хэл сурсан хэрэг биш, хэдэн хэллэг, хэдэн өгүүлбэр тогтоосон хэрэг, **хэдэн үг хэлээд, хэрэг болж байгаа дүн үнэлгээ авах** гэдэг л сэтгэлгээ хэвшиж зуршиж дээ. Иймээс их, дээд сургуульд элсэгчдэд дунд сургуульд үзсэн сураагүй, мэдээгүй, заагаагүй гэх болгоныг эхнээс шахуу эргэж заах, дутууг гүйцээх гэж “үйлээ үзэх” шахуу л юм болж байна. **Унших биш**, харин **уншсанаа ойлгох дадал, чадвар** суралцагчид, элсэгчдэд **дутуу** дундуур байгааг юу ч мэдэхгүй, сураагүйгээс болж байна гэж буруу ташаа онош тавьж баахан халуурдаг дутагдал ч бас бидэнд байна.

Энэ удаа бид сургалтын эхний шатанд учирч байгаа дээрх таагүй үр дагаврыг арилгах, нэг үгээр хэлбэл, мэдлэгийн болон унших техникийн дутуу хөтүүг ч биш, харин **уншиж байгаагаа ойлгох** дадал чадварын дутууг нөхөж гүйцээхийг эрхэм болгож энэ хэдэн шавь нараа **тэнхрүүлж** чамбайруулах талаар хичээлийн анги-танхимд гүйцэтгүүлж байгаа зарим даалгавар, ажилбарууд, уншуулж байгаа зарим стратеги, уншлага үйлдэх үеийн менежементийн талаар товч боловч гүйлгээд үзэхэд, уншигчдад маань сонирхол төрөх, бас ч тэд хэрэг болж ч мэдэх юм гэж “хэрэгт дурлах” юун магад гэж санав.

### Уншихуйн мэдрэмж

**1. “Уншихаа мэд(р)эх”.** Манай орны үндэсний зарим эрдэмтэд (Хишигт Я., 1999; Хишигт Я., 2007;) сургагчдын үзэж байгаагаар “... монгол хүний аялга-дуудлагын онцлогийг мэдрэх чадвар нь байгалиас заяаж зөнгөөрөө цар чинээндээ хүртэл хөгжсөн сонголын мэдрэмжид тулгуурлан төлөвшиж хөгжих боломжтой байдаг. Энэ бол монгол хүн аливаа гадаад хэлийг хялбар сурах байгалиас заяасан их нөөц, боломж чадавх юм. Харин энэ боломжийг зүй зохистой ашиглаж сурах нь өнөөгийн гадаад хэлний аливаа сургалтын нэн чухал зорилт...”(1999;158 тал;) гэж үзжээ. Алив хүн хэлж-ярьж байгаагаа өөрөө ойлгож байдаг учраас аялга дуудлага, ая хөг, айзам хэмээ аяндаа тааруулж тохируулж байдаг аж. Тэгвэл хүний хэлж-бичсэнийг уншиж байхдаа бичиж байгаа хүний ойлгож байгаатай яг адил хэмжээнд ойлгосон байхын тулд аялга дуудлага, ая хөг, айзам хэм, утга шигтгээг нь уншигч өөрөө тааруулж тохируулж бүтээлчээр суралцах шаардлагатай тулгардаг байна. Яаж сургах вэ гэдэг ярвигтай хэдүй ч яаж уншуулснаас яаж ойлгох нь шалтгаалдаг байж болох ажээ. Уншихаа мэд(эр)вэл уншигч болдог. Мэдээ-чимээ(message)-г мэдрдэг болтол нь уншуулах бэлтгэлтэй байх нь багшийн хийх ажил юм. Өмнөх үгээ арын үгээр хөглөн, ёстой л ар араас нь “аялуулж” уншуулна даа. Суралцагчид яаж уншихаа мэдэхгүй, юу уншиж байгаагаа огт мэдрэхгүй түүртдэг атлаа, харин хэлний тухай үзсэн, дуулсан зүйл чамлахааргүйгээр барахгүй, тэдний танилцуулж байгаагаар, “үзээгүй дүрэм, уншаагүй сэдэв гэж бараг ч үлдээгүй” байдаг бололтой юм. Бидний тавьж байгаа зорилго бол суралцагчдын унших хурд, ойлгоцыг нэмэгдүүлэх, хурд хүчтэй уншигч бэлдэх явдал болж байна. Уншлагын хурд, ойлгоц хоёрыг тодорхойлж байдаг хүчин зүйлүүдийн нэг нь хүний нэг харалтаар (харааны багтаамж) ойлгож, ухаарч хүч хүрч байгаа үгийн тоо хэмжээ байдаг. Нэг харалтаар оюутан суралцагчид хэдүй олон үг уншиж ойлгож байна вэ, тэдний унших хурд төдий өндөр, ойлгоц төдий зузаарч байдаг зүй тогтолтой. Оюутан суралцагчид салгаж салангид үг дуудах төдийд уншиж суралцах биш, харин ая хөг, аялга айзам, хэллэг дуудлага тэгширсэн бөл нэгжүүдээр унших чадварт суралцсан байх ёстой болж ирж байна. Тэднийг үг үгээр салгаж саланги саланги дуудах технологиор биш, харин ая хөг, аялга айзам

тэгшлэх, хэллэг дуудлага гүйцээх багц нэгжүүдээр уншуулж сургах үр дүнтэй, хэрэглээтэй нэг барил бол аль ч өгүүлбэрт гарч байгаа мэдээ чимээг мэдрэхүйн хэд хэдэн бөл болгон зааглан уншуулж сургасан байх явдал юм. Энэ бол тухайн өгүүлбэрт гарч байгаа мэдээ-чимээ(message) болгоныг “чимх чимхээр”, “атга атгаар”, бүр “тэвэр тэврээр” утга хөвөртөл нь “хөглөн уншуулж” сургаж байгаа нэгэн техник барил юм. Бидний өмнө нь ойлгож байсан шиг үг хэллэг, өгүүлбэрт ая хөг оруулах биш, харин үг хэллэг, өгүүлбэрт бүгж, тэнд орогнож байгаа мэдээ чимээнд ая хөг, айзам хэмнэл, хэллэг дуудлага оруулан уншиж сурах хэрэгтэй болж байгаа хэрэг л дээ. Дор хаяад өгүүлбэрт гарч байгаа мэдээ чимээг чимх чимхээр, цаашлаад атга атгаар, бүр тэвэр тэврээр тэнхээ оруулан уншиж сурах техникт суралцаж эхэлнэ дээ. Тус их сургуулийн сэтгэл-судлалын нэгдүгээр дамжааны оюутнуудаар англи хэлний хичээлээр уншуулсан эх бичвэрээс авсан **“Medical research has confirmed that a joyful smile actually strengthens the immune system which fights against disease in the body.”** өгүүлбэрээр жишээлж үзье. Суралцагчдыг “А” ба “Б” гэсэн хувилбараар уншуулав. Эхлээд “А” хувилбараар уншуулж үзье:

- (1) Medical research
- ↓
- (2) has confirmed that
- ↓
- (3) a joyful smile
- ↓
- (4) actually strengthens
- ↓
- (5) the immune system
- ↓
- (6) **which** [the immune system] fights
- ↓
- (7) against disease
- ↓
- (8) in the body.

гэж найман бөл утга болгон (in “breath groups” by H.Douglas Brown. 20001) хуваарилж уншиж байв. Эхний уншилт, оролдлогоор бөл бөл богино богино байж болох бөгөөд энэ нь тэдний хурд, ойлгоцоос хамаарч байдаг. Харин хоёр дахь, гурав дахь уншилт, оролдлого, сургуулилтын дараагаас ойлгоц гүйцэж тэгшрэхийн хэрээр дээрх өгүүлбэрт гарч байгаа мэдээ чимээг арай утга зузаан бөл болгон хуваарилж, хөглөн уншиж сурдаг. Бөл арай уртасч, утга арай зузаарч ирж байгаа хоёр дахь буюу “Б” хувилбараар уншуулж үзье:

- (1) “Medical research has confirmed that
- ↓
- (2) a joyful smile actually strengthens the immune system
- ↓
- (3) **which** fights against disease in the body . гэж гурав хөглөн гурван өгүүлбэр болгон нэг нэг амиар (in breath groups), нэг харалтаар (at one glance) унших үед ногдох үгийн тоо нэмэгдэхийн хамт утга улам зузаарч өгүүлбэрийн утга гарт баригдан аманд амтлагдаж ирдэг. Ингэж уншиж



байгаа зүйлийн утга санааг бүр гартаа атгаж, амандаа хүлэж, энгэртээ тэвэрч байгаа шигээр мэдэрч баймаах нь л, сая уншиж ойлгож сурч эхэлж байгаа нь тэр юм. Сургалтын цаашдын явцад багшийн аялга дуудлага, ая хөг оруулан уншиж байгаагаас суралцагчид санаа авч тэдний гар дээр байгаа эх бичвэр дээрээ доошоо хошуутай зурлага {↓} хэрэглэн бие даан хуваарилалт хийж эхэлдэг. Өгүүлбэрт гарч байгаа мэдээ чимээнд ая хөг, аялга дуудлага, хэм айзам, учиг шигтгэн уншиж сурдаг. Ийм маягаар уншиж ойлгох дасгал сургууль хийлгээд байвал багшийг дагаж, үгүй бол бэлэн бичлэг “дууриах унших” гэх биш, харин аль болох ая хөг хөвөртөл, өгүүлбэр утга хөвчиртөл хөглөн унших гэж хөлс хүчээ гаргаж хичээдэг болж ирдэг. Багшийн хийх ажил бол мэдрэмжийн бөл бөлөөр утга оруулан унших эхийг нэг талаас “сэдэв сонгож”, нөгөө талаас “агуулга сунгаж” уншуулахаар бэлтгэлээ базаасан байх явдал юм. Ийм стратеги барьж ажилласнаар суралцагчид уншиж байгаадаа анхаарал түлхүү хандуулж эхэлдэг. Суралцагчдын ойлгоц, унших хурдыг ойртуулах эхний алхам хийгдэж байгаа хэрэг энэ юм. Ингэснээр “Биеэ мэдвэл хүн, Бэлчээрээ танивал мал” гэдэг шиг, суралцагчид “**уншихаа мэддэг**”, “**мэдэрдэг**” болж эхэлдэг. “**Уншихаа мэдвэл уншигч**”. Энэ л гол үр дүн гэхүү дээ. Цаашдаа багшийн бөл бөлөөр уншихаар бэлдэж хуваарилсан бэлэн хэрэглэгдэхүүн дээр биш, харин багшийн боловсруулсан “сунгуу” эх дээр бөл бөлөөр унших дадлага ажилбарыг суралцагчдаар өөрсдөөр нь хийлгүүлэх нь хамгийн оновчтой хувилбар юм. Бидний багшлах ажлын практикаас харахад, багшийн бэлдэж зориуд хуваарилж уншуулсан, эсвэл хуурцаг, си-ди (CD) дагаж уншуулахаас, харин өөрсдөөр нь хуваарилж уншуулах гэж оролдуулах нь хэд дахин дээр үр дүнтэй ажилбар болдог. Учир нь өөрөө хуваарилж унших гэж оролдлого хийгээд байсан суралцагч нөгөө багшийн бэлдсэн бүдүүвч, аль эсвэл хуурцаг, си-ди (CD) дагаж дууриах уншсанаас ойлгоц, хурд, уншиц нь хэд дахин дээрдэхээс гадна, **бие даах**, “**толгой даах**” чадвар хавьгүй түргэн суудаг. Тэгээд ч унших зүйлээ **яаж уншихаа** өөрсдөө хуваарилж бэлдсэн болохоор багшийн өмнө, өрөөл бусдын өмнө нүүр улайхгүй уншиж үзүүлэх, ойлгож чаддаг боллоо гэдгээ харуулах боломжийг ч бүрдүүлдэг. Иймээс тэд уншиж байгаадаа илүү итгэл үнэмшилтэй болж, уншиж байгаа зүйлийнхээ жинхэнэ эзэн боллоо гэж эрмэгшиж ирдэг. Харин багш уншуулах эх бичвэрийн сан бүрдүүлэх, аль болох хуваарилан уншуулах арга техник дээр эхний ээлжинд анхаарал тавих хэрэгтэй. **Уншихаа мэддэг хүн уншихгүйгээр сууж чадахаа байдаг.** Суралцагчид өгүүлбэр болгоныг бие даан хуваарилан өөрөө ая хөг оруулж унших нь ёстой л хийгээд хийгээд уйдаагүй зугаатай шахуу, барагдахгүй хамгийн, хамгийн үр дүнтэй, суралцагчдад ачаалал дарамт болоод байх нь ч бараг байдаггүй. Ингэснээр аялга дуудлага, айзам хэмнэл нь гүйцэж тэгширсэн, багцарсан хэллэг, өгүүлбэрээс айх, бэргэх зүйлгүй болж ирдэг. Ингэж шавь нараа, “амаа мэдвэл агт” гэдэг шиг, “уншихаа мэддэг уншигчид” болгож авдаг юм.

**2. Учиг утга мэд(р)эх.** Үндэсний эрдэмтэд судлаачдын үзэж байгаагаар “... үг-утгын мэдрэмж бол хүний хэл-ярианы мэдрэмжийн цөм, түүний онцлогийг мэдрэх мэдрэмжтэй болгон төлөвшүүлж хөгжүүлэх асуудлыг бүр балчир бага наснаас нь бодож боловсруулуштай ...” (1999; 159-161 тал) байгаа ажээ. Гэтэл гадаад хэлний сургалтад эх бичвэрийн түвшинд ялангуяа, хийсвэр үг-утгын мэдрэмж төлөвшүүлж хөгжүүлэх ч гэхээсээ илүү, “үгэнд үүртүүлж утганд түүртүүлж” (үг голдуу тогтооно, текст голдуу цээжилнэ), бүр ч “төөрүүлж будлиулаад” байгаа юм болов уу ч гэж

бодох юм. Бичвэрт гарч байгаа мэдэхгүй, ойлгохгүй гэж сангагдсан үг болгоныг саланги саланги дуудаж, салган “тасдаж” бичээд толь хөтөлдөг нь, ёстой л хөг нь аль хэдийнэ өнгөрсөн арга, техник болж байх шиг байна. Нэхий зүйвэл дээл болдог гэдэг. **Үг зүйвэл** ч бас **утга болох бус уу.** Ганц мод гал болдоггүй, ганц хүн айл болдоггүй гэдэг. **Ганц үг ч бас утга эс болох бус уу.** Нэхий зүйж дээл **бүтэн** болдог гэдэг шиг, үг зүйж утга (учиг) **бөх** болдог байна. Ингээд бодвол бичвэр гэдэг үнэхээр үг зүйж утга аргамжсан их тал, усалгаа үрсэлгээ тохирсон, уяа сойлго таарсан, орц гарц жигдэрсэн, гүйлгээ сэлгээ тэгширсэн, зүйдэл оёдол цөм гүйцсэн газар юм уу даа. **Үг** уншигдаж, бидний “амин мэдрэмж” (Я. Хишигт)-ийн нэг төрөл болох харааны мэдрэмжид өртөж байдаг бол, харин **утга** (үгийн учиг) бидний “сэтгэцийн мэдрэмж” (Я. Хишигт), түүний дотор “**хэл-ярианы мэдрэмж**” (Я. Хишигт)-ийн цөм болох “**үг-утгын мэдрэмж**” (Я. Хишигт)-ид өртөж байж “учир нь олдож хужир нь тунгаагддаг” жамтай аж. Хажуу үгэндээ хань, дэргэдэх үгэндээ дэмжлэг, зэрэгцээ үгэндээ цуцал болж байдаг аж. Дэм дэмэндээ дээс эрчимдээ гэдэг энэ дээ. Гэтэл салангид үг дуудаж, салгаж толь хөтөлдөг нь “үг үг зүйж утга утга аргамжсан” тэрхүү бэхэлгээ бөхөлгөөг үгүй хийж эх бичвэрээс нь ховх татан холдуулж, ёстой л “буянд нь бузар оруулж”, “бодыг нь хөтөлж” байгаа хэрэг арай биш байгаадаа ч гэж эргэлцэх үе ч гарах юм. Уяа нь алдарч, товч нь тас үсэрч байгаа шиг л болох юм. Үг чухал ч, утга бүр ч чухал. Үгээ мэдэх чухал ч, утгаа мэдрэх улам ч чухал. Үгэн дээр ажиллах, утга ухааруулах арга барил цагийн эрхээр өөрчлөгдөж, сэлбэгдэж сэлгэгдэх ёстой болж байна. Үг үгээр нь салгаж таниулах биш, харин багц багц(chunks of language)-аар нь таниулж, үгийн төдийгүй утгын мэдрэмжтэй болгож сургах нь гадаад хэлний сургалт-аргазүйн ажлын зайлшгүй бүрэлдхүүн, салшгүй хэсэг бид үзэж байгаа юм. Хэлний үгийн сангийн сургахзүйн нэгж нь дан үг (**words or polywords**) байдаг гэдэг уламжлалт ойлголт одоо үлэмж томсгосон дидактик нэгж болох хамжсан хэллэг (**collocations**), багцарсан хэллэг (**institutionalized utterances or fixed expressions**), малгай өгүүлбэр буюу жааз өгүүлбэр (**sentence frames or heads**) (Levis 1993; 1996;) болжээ. Үгийн сангийн нэгж үлэмж **биежиж, утга** ч улам **зузаалж** ирж байгаа энэ зүй тогтлыг сургалт-аргазүйн ажилд заавал харгалзах хэрэгтэй болж байна. Суралцагчид тухайн саланги саланги үг мэддэг ч, хичнээн зүйдэл орж нэг дээл болов гэдэг шиг, хэдэн үг яваад нэг бөл утга болж гүйцэж байна вэ, хэдэн үг бөл болж нэг утга дүүргэж байна вэ, өөрөөр элбэл нэг бөл утга гүйцээж байгаа хэлний нэгжүүд аль аль вэ гэдгийг мэдэрч байгаа нь огт харагддаггүй, “**үг болгон нүдэнд тусч байгаа хэрнээ учиг нь баригдаггүй, утга нь олдоггүй**” нэгэн гэм байдаг. Суралцагчид хажуу, дэргэд, зэрэгцээ үгээ зүйж унших ч үгүй, утга үрслэж, утга бүрдэж байгаа газар хаана байгааг анзаарч байгаа ч юм үгүй, утга үгүй хийх шахсан саланги саланги үгийн толь хийсэн болж, мэдэх үг ч үгүй, мэдрэх утга ч үгүй шахуу үлдэх юм. Гэхдээ толь хийсэн шавь нараа буруутгаж байгаа хэрэг биш юм. Хэлбэрийн төдий ажил даалгавар хийж хэвшиж зуршиж байгаад л хэргийн учир байна. Чухам бичвэрт л суралцагчдын шинээр сурч эзэмших (learning), хадгалах (storing), сэргээх (retrieving), эргэлтэнд оруулах (recycling)- д хэрэгтэй байгаа үг хэллэгүүд “шүтэлцэн багцарч”, “байр байраа олж жагссан” байдаг байна. Бид үг хэллэгийг салангид салангид, дан дангаар нь салгаж одоогийн сурах бичигт байдаг шиг “шинэ үгийн жагсаалт”, толь бичигт байдаг хэлбэрт оруулаад, л ямарч барих уяа учиггүй болтол нь салгаж сарниулдаг, эвээ олсон хэллэгийг “эвдэж”, утгыг нь ёстой л “үйрүүлж яйруулж” өгдөг, эргэж



эвийн олж чадахаа байтал нь эв хавгүй байдалд оруулдаг байна. Харин бид одоо үг үг эвлэж, утга амилж байгаа, ёстой л хэрэглээндээ байгаа газар газар дээр нь барьж авах гэж хичээдэг. Энэ бол үг үгээр түүж **үгэнд толь** хөтөлж байгаа хэрэг биш, харин үг үг зүйж, **утганд учиг** хөтөлж сурч байгаа хэрэг юм. Хэлэгдэж уншигдаж байгаа газар газраар, бөл утга “бүрж” байгаа үгийн сангийн томссон дидактик нэгж нэгжээр хэлэгдэхүүний, уншигдахууны толь хөтөлж эхэлдэг юм. Ингэснээр **“уншихаа мэд(р)эх”**-ээс одоо **“утгаа мэд(р)эх”** гэж хичээж ирдэг. Эхлээд утга эвлэж байгаа газар, хуниас нугалаа, залгаа зангилаа, углаа уулзвар болгоноор утга бөллөж байна гэж танин мэдэрч, ялган түүж уншиж сурдаг. Бид сургалтын эхний үед үгсийн сангийн дээр дурдагдсан багцарсан нэгжүүдээс хамжаа (хөрш) хэллэгүүд (collocations), түүний 5-7 төрөл дээр ажиллуулж байгаа юм. Тэдгээр хамжаа хэллэгүүдийг тухайн нэг өгүүлэмжээс таньж, ялган уншуулсан нэг ажилбараар жишээлж үзье. Суралцагчид хэдэн үг яваад нэг утга-багц хэллэг болж байна вэ гэдгээ эхлээд 1) уншиж хэд хэд үзнэ, 2) хэлэлцэж ярилцана, 3) бичиж сийрүүлнэ. **“In a study of violence against minors, more than half of the cases studied involved some kind of sexual abuse. Incest alone accounted for three out of 10 cases of the child abuse”**. Энд 1) violence against minors; 2) a study of violence against minors; 3) more than half of the cases studied; 4) sexual abuse; 5) some kind of sexual abuse; 6) to involve some kind of sexual abuse; 7) incest alone; 8) child abuse; 9) three out of 10 cases of child abuse; 10) to account for three out of 10 cases of child abuse; гэсэн дор хаяад 10 бөл утга бүхий хэллэг байна гэж таньж, түүж унших юм. Ингэж ялган уншиж, түүн тэмдэглэж сурвал салангид үг, тухайлбал, minor(s), incest, to involve, to account for... гэж хөөцөлддөг араншингаа гэж эхэлдэг. Аль болох богино богино бөл хэллэгээс аль болох бүхэл бүхэл хэллэг рүү (1 □ 2, 4 □ 5, 5 □ 6; 8 □ 9; 9 □ 10) ахих замаар хэд хэд уншиж, унших хэлэх болгондоо, бичиж нүдлэх болгондоо дотроо сонсч, мэдээ чимээг мэдэрч ойлгож ирдэг. Үг үгийн залгаа зангилаа, оёдол зүйдэл, уулзвар углуурга, сэлгээ гүйлгээ, нугалаа нугалам, зөрөө гараа, гаралт оролт дээр баруун зүүнгүй ажиллах гэдэг энэ дээ. Цаашлаад, утга баригдаж, учиг тэмтрэгдэж байгаа учир дээрх хэллэгүүд эх хэлээр нь элдэв саадгүй буюу эхэлдэг. Мэдээ чимээ мэдрэгдэж ирж байгаа учраас үгэнд толь хөтөлж хэрэг үгүй болж, харин **хамжаа хэллэг** болгонд **утга суулгаж, учиг зангидаж** сурдаг. Нэг үгээр хэлбэл, үгэнд толь хөтөлж сурч байгаа хэрэг биш, харин **утганд хөтөч хийж** сурч байгаа хэрэг юм. Биежиж, утгажиж ирж байгаа учир салангид ирж шиг хөнгөдөөд, хөвсөгнөөд байхаа больж, ой тархинд бүүхаар дайны жин дардаг, утганд “бариулж” уураг тархинд, ёстой л суга татуултлаа “соруулдаг” юм шиг байна. Тархинд ингэж “татуулсан үг хэллэг” тасраад тасраад, салаад салаад ер нь хаа хүрэх юм бэ. Сургалтын цаашдын явцад уншиж байгаа өгүүлэмжид гарч байгаа богино богино хэллэг болгоныг заавал ялган уншиж, түүж бичиж төвөг удах хэрэг үгүй болж ирдэг. Богино богино бөл хэллэг байна гэж анзааран уншиж, утга мэдэрч сурахын хэрээр цаг хугацаа аяндаа чөлөөлөгдөж эхэлдэг, харин шинэ шинэ, бүхэл бүхэл утгат хэллэгүүдийг анзаарч, утга учгийг ухаарч сурахад цаг гаргах хэрэгтэй болно. Иймээс “дахин сурах” биш, харин “сурсан (богино богино бөл хэллэг) дээрээ сурах (бүхэл бүхэл бөл хэллэг)” хэрэгцээ л байнга үүсч байдаг. Сурсан дээр нь үүсч байгаа хэрэгцээ тул суралцагчдыг төдийлэн түүртүүлээд байх бэрхшээл саад болдоггүй, харин ч ирлэж хурцалж өгдөг ажээ. Харин одоо хамжаа хэллэг (collocations) дээр ажиллуулсан арай өөр нэг даалгаврыг авч үзье.

Суралцагчид гадаад хэлээр гэрээр бие даан уншиж ойлгосон байх ёстой өгүүлэмж (Unemployment around the world)-ээс, тухайлбал, ажилгүйдлийн түвшин буурч байгаа (А хувилбар-г), ажилгүйдлийн түвшин өсч байгаа (Б хувилбар)-г харуулсан 15-20 хамжаа хэллэг түүж ялгаад, жагсааж бичих даалгавар гүйцэтгэв. Жирийн суралцагчийн гүйцэтгэл 30%-иас төдийлэн хэтэрдэггүй нь ажиглогдов. Гэтэл мань суралцагчид орчуулсан атлаа дээрх хэдэн хэллэгийг олж ялгаад, гүйцээгээд биччих бядгүй байгаа нь өөрөө орчуулсан биш, “өрөөл бусдын буянаар будаа тээж яваа” хэрэг байжээ. Ингэж л “орчуулга хийсэн нэрээр” сураагүй байж “сул дүн”, ойлгоогүй байж “онц дүн” тооцуулдгийн сонгодог нэг жишээ энэ буюу. Энэ бол гадаад хэлд суралцах арга биш, харин гадаад тэр хэлэнд “гацаадаг ганц арга” гэхээс өөр юу гэх вэ. Чухам иймээс л бид орчуулга гэхээсээ илүү, хамжаа хэллэг (collocations)-т хамаг анхаарлаа хандуулж байгаа хэрэг л дээ. Харин хамжаа хэллэг (collocations)-т суралцсан хэд нь хамаагүй дээр орчуулдаг, орчуулж ухаардаг, орчуулах бэлтгэлтэй болж чадаж байдаг гэх үү дээ.

**3. Хэлзүйн бүтэц-байгууламжаа мэдрэх:** Манай зарим судлаачид, эрдэмтдийн үзэж байгаачлан, “... орчин үеийн бичгийн соёл боловсролтой хүмүүс харилцаж байгаа хэлнийхээ дүрэм-найруулгын онцлогийг мэдрэхгүй, дүрэм-найруулгын зүй тогтлыг ашиглах дадал чадваргүй байхын аргагүй...” (1999, 161 тал;) ажээ. Харамсалтай нь, манай элсэгчдийн дунд англи хэлээр дунд сургуульд уншсан сэдэв олон, үзээгүй дүрэм бараг үгүй шахуу атлаа тэдгээрийг **ашиглах дадал чадвар** даанч хангалтгүй ирэх юм. Тэд дүрэм-журам үзсэн гэх атал түүгээр бүтээсэн, түүнд боосон, зангидсан мэдээ чимээг огт **мэдрэхгүй, ойлгохгүй** байхыг яана. Бидний ажигласнаар энэ нь дүрэм-найруулгадаа биш, харин эх бичвэрт гарч байгаа өгүүлбэрийн урт богинод байх шиг байна. Өгүүлбэр (өгүүлбэрийн байгууламж) нь **уртдаад**, түүндээ л түүртээд байдаг бололтой юм. Урт өгүүлбэрийг ахарлан, богино богино болгон уншиж үзээд байвал түүнд байгаа мэдээллийн учир олддог, учиг тайлагддаг гэдэгт шавь нараа сургаж авах нь багшийн барих чухал тактик байж болох юм шиг байна. Орчуулж дийлэхгүй, учир нь ч ойлгогдохгүй байна гээд ор тас зүгээр суухын оронд янзаар янзаар богиносгож уншиж үзээд байвал ойлгох гэж оролдох нь овоо нэмэгдэж ирэх юм. Богино богино болгон ахарлан уншсанаар уншигч бас нэг түүртлээс салж эхэлдэг. Үзэж судалсан нь хэрэглэгдэж, хэрэглээнд орж байгаа болохоос, “дахин сурч” байгаа хэрэг биш юм, харин ч сурсанаа, ёстой л “ашиглалтад оруулж” байгаагаа мэдэрч эхэлдэг. Хэлзүйн холбох хэрэглүүр (functional conjections), үгийн сангийн холбох хэрэглүүр (content lexical ties) бүхий хэлзүйн бүтэц-байгууламжуудыг мэдэрч сурахад анхаарал тавих хэрэгтэй болж ирж байна. Нэг төрлийн зэрэгцсэн олон гишүүнт энгийн өгүүлбэрийг гишүүн бүрийн, харин хэд хэдэн гишүүн өгүүлбэр бүхий хавсарсан, эсвэл холимог нийлмэл өгүүлбэрийг гишүүн өгүүлбэр болгоны тоогоор ахарлан салгаж унших техник эзэмшүүлэх явдал дор хаяад сургалтын эхний шатанд яах аргагүй хэрэг болж ирдэг. Жишээлбэл: **A healthy, vigorous, enthusiastic and well-educated adolescent and young adult population is essential to the vitality of any society**. Нэг төрлийн олон гишүүн зэрэгцэн дараалан байрласнаас ойлгоход “уртдах” бэрхшээл үүсч байгаа юм. Үүнийг давах стратеги нь хэлэхүйн бөл болгон уншиж үзэх, уншиж сургуулилах, хэлэгдэж байгаа газруудаар нь хэлэхүйн толь хөтлүүлж эх хэлээрээ эргэцүүлж үзэх явдал юм. Суралцагчдыг бие даалган эх бичвэр дээр ажиллуулах,



байнгын эрэл хайгуулд оруулах, сонирхол төрүүлэх чухал ажлын нэг бол яах аргагүй энэ мөн юм. Сургалтын эхний шатанд “нэр үг + нэр үг”, “тэмдэг нэр+ нэр үг”, “үйл үг + нэр үг” гэсэн хөрш буюу барьцалдсан хэллэг хэллэгээр ажиглалт хийлгүүлж, тэмдэглэл хөтлүүлдэг байвал сайн. Эхлээд хамгийн бага, суурь нэгж болох хоёр насны хүн амын тухай яригдаж байгаа гэдгийг ажиглуулахаас эхлэх гэж үзэв. Учир нь суралцагчид эхний уншилтаар хоёр насны хүн амын талаар гарч байна гэж огт мэдрээгүй байв.

population: **young adult population; adolescent population;**

Дараа нь, тодотгосон, тэмдэг нэрээр утга өргөжиж болгонд шүтэлцсэн арай томгосон хоёр урт бөл болж байна гэж таниулах гэж оролдсоныг дараах уншлагаас ажиглаж болох юм.

population: **a well-educated young adult population; well-educated adolescent population;** population: **an enthusiastic young adult population; enthusiastic adolescent population;**

population: **a vigorous young adult population; vigorous adolescent population;**

population: **a healthy young adult population; healthy adolescent population;**

Сүүлд нь утга гүйцэд жагссан хоёр бөл үүсгэжээ гэдгийг уншиж таниад ирэв:

population: **a healthy, vigorous, enthusiastic and well-educated young adult population;**

population: **a healthy, vigorous, enthusiastic and well-educated adolescent population;**

Энд уншсанаараа толь хөтлөх ажилбар гэхээсээ илүү, утга хөглөх, утга таниулах ажиллавар хийгдэж байна. Нэг үгээр хэлбэл, үгэнд толь хөтлөх биш, харин хамжаа хэллэг болгонд учиг суулгаж, мэдээ чимээ оруулж мэдэрч сурч байна. Хэт удаж байна, удааж байна гэж бодож байж магадгүй, гэхдээ тийм биш юм. Учир нь унших процесс угаасаа дахин дахин эргэж харах, тодотгох, ухаарах, эргэцүүлэх нэгэн ёсны гүйлгээд өнгөрдөг, урсамхай байдаг сонсохуйн болон ярихуйн процессээс эрс ялгаатай танин мэдэх процесс байдаг шүү дээ. Бичвэрт гарах шинэ үг хэллэг, айлссан үг, багцарсан үг хэллэгийн учир ухааныг олж сурах гэж мэрийж эхэлдэг. Иймээс үг болгонд толь хөтөлж сурч байгаа хэрэг биш, харин хэлэгдэхүүн, уншигдахуун болгонд хөтөч хийж сурч байгаа хэрэг юм. Ерөнхий боловсролын дунд сургуульд суралцагчид нэг л гишүүн өгүүлбэр бүхий хавсарсан нийлмэл өгүүлбэр голдуу заалгадаг, иймээс тэд нэг гишүүн өгүүлбэр бүхий байгууламжийг ухаарах төдийхнээс хэтэрдэггүй. Гэтэл академик буюу салбарын чиглэлтэй эх бичвэрт өгүүлбэр бүрэлдэхүүний хувьд зузаарч, уртасч ирдэг. Өгүүлбэр зэрэгцсэн хэд хэдэн гишүүнээр, түүнчлэн хавсарсан хэд хэдэн гишүүн өгүүлбэрээр өргөжиж, улам уртасч ирдэг. Нэг үгээр хэлбэл, өгүүлбэр ойлгож ухаарах гэхээр “уртдаад байдаг зовлон” нүүрлэж эхэлдэг гэсэн хэрэг л дээ. Чухам ойлгохгүйн зовлон эндээс босч ирдэг дээ. Үүнээс гарахын тулд суралцагчдын бага боловч туршлагыг ашиглах хэрэгтэй болдог юм. Нэг гишүүн бүхий хавсарсан нийлмэл өгүүлбэрт байгаа мэдээ сэлтийг ойлгох, ухаарах туршлага суралцагчдад бүгдэд нь биш юмса гэхэд, тэдний цөөнгүй хэсэгт байдаг. Гэтэл мэргэших салбарын эх, бичвэрт хэд хэдэн гишүүн өгүүлбэр зэрэгцсэн байх нь элбэг байдаг. Чухам энд суралцагчдын англи хэлээр энгийн өгүүлбэр(10 basic sentence patterns by Homsky)

ойлгодог туршлагад дүлдуйдахаас өөр аргагүй болдог. Энэ нь уртдаад байгаа нийлмэл өгүүлбэрүүдийг энгийн өгүүлбэр болгон задлан уншуулах гэж үзэх хэрэгтэй дээ. Ингэснээр урт өгүүлбэрийг уншуулж ойлгуулах арга барилд суралцах нөр их чимхлүүр ажил ундарч эхэлнэ дээ. Судлаачдын (Krashen S. D.) үзэж байгаагаар суралцагчид “... мэдээ чимээ (messages)- г ойлгож ухаарахын хэрээр өгүүлбэрзүйн байгууламждаа амдаж ордог” зүй тогтолтой ажээ. Харамсалтай нь бид ийм уртдасан өгүүлбэр бүхий байгууламжууд уншуулахаас сүрдэж, бас бэргээд байдаг. Тэгээд одоо их сургуульд сурч багштайгаа байхдаа “уртдаад” байгаа эдгээр бүтэц, өгүүлбэрзүйн байгууламжуудын учрыг олж сурахгүй бол тэгээд хэзээ үүнийг сурах юм бэ? Нэг уртавтар өгүүлбэрийн дотор багтсан өгүүлбэр (embedded sentence)-үүдийг суралцагчид ойлгож мэдрэхгүй байх нь элбэг байх юм. Иймээс тэдгээр өгүүлбэрүүдийг **таниулах уншуулбар** хэрэгтэй болж ирдэг. Тухайлбал, нийгмийн ажлын I ангийн суралцагчдаар уншуулсан “багтсан өгүүлбэр” таних гурван янзын уншуулбар хийлгүүлсэн жишээг авч үзье. Бидний **уншуулбар** гэж нэрлээд байгаа нь уншихад урт, ойлгоход “уртдаад” байгаа зэрэгцсэн олон гишүүн бүхий энгийн өгүүлбэр, аль эсвэл хэд хэдэн гишүүн өгүүлбэр бүхий хавсарсан болон холимог нийлмэл өгүүлбэрийг суралцагчийн хүч хүрэх хэмжээний хэд хэдэн бөл богино богино хэллэг, эсвэл хэд хэдэн бөл богино өгүүлбэр болгон уншуулж үзсээр байгаад, нэг талаас ойлгуулж байгаа, нөгөө талаас ойлгоод авч байгаа хэрэг юм. Одоо яаж уншуулж, бас яаж уншиж үзэж болохыг сургалтын эхний шатны үед “ойлгоход уртдаад” байдаг гэж болох зэрэгцсэн олон (6) гишүүнтэй (**тодотгов**), хоёр (**who**) гишүүн өгүүлбэр багтаасан доорхи холимог нийлмэл өгүүлбэрээс ажиглаад үзвэл ямар вэ?

A. “Dix was horrified to find these poor unfortunates (1) **caged**, (2) **chained**, (3) **bound**, (4) **inadequately fed**, (5) **abused**, and (6) **tortured** by the people **who** should have been their protectors, but **who** had instead become their captors.”

- 1) Dix was horrified to find these poor unfortunates **caged**.
- 2) Dix was horrified to find these poor unfortunates **chained**.
- 3) Dix was horrified to find these poor unfortunates **bound**.
- 4) Dix was horrified to find these poor unfortunates **inadequately fed**.
- 5) Dix was horrified to find these poor unfortunates **abused**.
- 6) Dix was horrified to find these poor unfortunates **tortured** by the people **who** should have been their protectors.
- 7) Dix was horrified to find these poor unfortunates **tortured** by the people **who** had instead become their captors.
- 8) The people should have been **their** protectors.
- 9) The people had instead become **their** captors.

Харин дээрх өгүүлбэрт байгаа **who** нь хоёрдмал шинжтэй, хэлзүйн талаасаа, гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн, бас түүнийг гол өгүүлбэртэй холбож байгаа холбох төлөөний үг, харин дискурсийн талаасаа, тодорхой хэсэг хүн (the people)-ийг төлөөлж байгаа, “орлож” байгаа үг буюу **референт** юм. Гэтэл энэхүү **референт** болох “the people” –ийн цаана хэн байна вэ, хэнийг хэлээд байна вэ гэдгийг ухаж ойлгож байгаа юм суралцагчдад ер алга байв. Дээрх өгүүлбэрт мөн



л референт болох *their* – ийн жинхэнэ үг **ямар үг** болох, **хэнийг** төлөөлж байна вэ, **хэнийг** хэлж байна вэ гэдэг бас л бэрхшээл дагуулсан, ойлгоц будиулсан үг байлаа. Иймээс дискурсийн доторх референтийн холбогдлууд (жинхэнэ үг)-ыг олуулах, таниулах, илрүүлэх, боловсруулах чадвартай болгох гэдэг ёстой л багшийн санаа тавьдаг байх нэг номерийн асуудал байдаг юм. Үг өгүүлбэрт хоёр субъект (эзэн)-ийн тухай яригдаж байна гэж дийлэнх нь ойлгож өгөхгүй будилж гарна биз дээ. Иймээс багш хэн хэний тухай яригдаж байна вэ гэдэгт уншигчдын анхаарлыг зориуд хандуулахаас өөр аргагүй болов. Хорих газар ажиллаж байгаа эрхтэн, тушаалтан хүмүүс (*the people*)-ийг хэлж байна уу, аль эсвэл хорих газар хоригдож байгаа, ёстой л “заяа нь хаясан хүмүүс” (*unfortunates*) болох сэтгэл мэдрэлийн өвчтөн хүмүүсийг хэлж байна уу, алив дахиад нэг уншаад үз дээ гэнэ биз дээ. Чухам үүний дараагаас л “*their protectors*” нь тэдгээр **сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийг** хамгаалагчид буюу “*the unfortunates’ protectors*”, харин “*their captors*” нь мөн тэдгээр **сэтгэл мэдрэлийн өвчтэй хүмүүсийг** дарамтлагчид буюу “*the unfortunates’ captors*” болж, тэднийг хамгаалах ёстой байсан хүмүүс маань харин ч тэднийг дарамтлагчид болсон байжээ гэж ойлгогдсоноор будлиан арилж, ойлгоц нэг мөр цэгцэрч ирэх нь тэр. Ингэж олон янзаар уншуулж үзээд байвал үртдаад байгаа өгүүлбэрийн утга учир олдож ирдэг. Мэдээ чимээг амдаж явсаар өгүүлбэрзүйн байгууламжаа ч гартаа хийгээд авч чаддаг болж ирдэг.

**4. Ойлголт, төсөөлөл (концепт)- өө мэд(р)эх** (“санаа босгох”): Дөхүүлэх чиглэлтэй асуулт тавьж “зориуд ойлголт, төсөөлөл, “санаа босгох” гэж уншуулах” бас нэгэн техник байна. Нэг ёсондоо, тодорхой эрэлт зориуд үүсгэх замаар мэдээ-чимээ, мэдээ-сэлтийг зориуд ухааруулах гэж байгаа хэрэг юм. Тухайлбал, дараах **“It enables studies to identify those elements commonly found in all societies, from those which are unique to a region or a specific country”** гэсэн өгүүлбэрт ямар хоёр зүйлийг харьцуулсан судалгаагаар (it=харьцуулсан судалгааг хэлж байгаа нь өмнөх өгүүлбэрийн утгаас тодорхой байгаа юм) тогтоох бололцоотой байна вэ гэж лавлахад, 1) нийтлэг элемент (*elements commonly found in all societies*); 2) өвөрмөц элемент (*elements which are unique to a region or a specific country*) хоёр төрлийн элемент харьцуулагдаж байгаа нь ухаарагддаг байх жишээтэй бөгөөд хэллэг хэллэгээрээ буюу хэлэгдэж байгаагаараа эв нь эвдэгдэхгүйгээр хэлэгдэж байна шүү дээ. Харамсалтай нь ингэж ухаарагдахгүй, бараг мэдрэгдэхгүй шахам байдаг. Ингэж ухаарагдаж, хэллэг хэллэгээрээ бууж байхаар бол тогтох нь ч амар, ойлгогдох нь ч хялбар, эргэлтэд орохдоо яг эв эеэрээ эргэж хэлэгдэж байна. Хүний ойгоос алга болно ч гэж үгүй, мартагдах нь ч бас үгүй шахуу л байх юм.

**5. Санаагаа** эх хэлээрээ **хураангуйлах**: Тухайн эх бичвэрт байгаа мэдээ чимээг зөв, гүйцэд ухаарсан эсэхийг таних хамгийн найдвартай хэрэгсэл бол, сүүлийн үеийн судлаачдын үзэж байгаагаар, эх хэлээр нь шалган тогтоох явдал гэж үздэг болж байгаа явдал юм. Энэ нь манай суралцагчдад гадаад хэлээр хүлээж авсан мэдээ мэдээллээ гадаад хэлээр гэхээсээ илүү, харин эх хэлээрээ ашиглах хэрэглээ өндөр байдагтай ч бас холбоотой юм. Тухайлбал, тодорхой салбарын агуулга, мэргэжлийн чиглэлтэй эх бичвэрийг уншдаг ойлгодог боллоо гэхэд түүнийг гадаад хэлээр сонсох хүн, харилцагч манай сургалт явагдаж буй орчинд алга байна шүү дээ. Тиймээс эргүүлж заавал гадаадаар яриулах гэх шаардлага, хэрэгцээ ч байхгүй байна шүү дээ. Эх хэлээрээ хураангуйлах нь гадаад эхийг

хэр зөв, үнэн, гүн, бат ойлгосны гэрч, бас нотолгоо болж байдаг гэдэг. Сүүлийн үеийн зарим судлаачдын (Hughes, A. 2003; Nuttall, C. 1982;) үзэж байгаагаар, гадаад хэлээр хураангуйлах, Үнэн/Худал, Тийм/Үгүй, зэрэг сургалтын уламжлалт ажилбарууд нь үнэн, зөв, гүн бат ойлгосны гэрч нотолгоо төдийлөн болж чаддаггүй ажээ. Тухайлбал, Үнэн/Худал ажилбарын 50%-ийг таах болоцоотой байдаг гэж дээрх судлаачид үзжээ. Иймээс Үнэн / Худал, Тийм, / Тийм биш уламжлалт даалгавруудыг эх, төрөлх хэлээр нь өгдөг байх нь зүйтэй гэсэн саналтай байгаа бөгөөд дор хаяад хоёр хэлээр хослуулах нь зөв гэж үзэх болжээ. Манай суралцагчдын 90% орчим нь, тухайлбал, орос хэлээр хураангуйлах дадал чадвар хангалтгүй, хураангуйн авцалдаат чанарыг алдагдуулсан (Алтанцэцэг Д., 2005; 2006.) байгаа нь тогтоогджээ. Түүний туршилтад оролцсон оюутны бичсэн 346 хураангуйн бүтцийг авч үзэхэд, 312 нь бүтцийн алдаатай байжээ. Заримдаа **“хураангуй”** гэхээсээ илүү, **“нураангуй”** болох, **“товчлох”** гэхээсээ **“огтлох”** болох нь ч олонх тохиолдол эзэлж байдаг л даа. Манай зарим судлаачид (Ганчимэг З., 2003; 2004,) орос, англи хэлээр эх товчлох монгол оюутан суралцагчдын дадал чадвар төдийлөн хангалтгүй байгаа гэсэн дүгнэлтэд мөн хүрчээ. Дунд сургуульд эх хураангуйлах хөтөлбөрийн шаардлага байдаг ч эргэж төдийлөн шалгагдахгүй учраас багш нар энэ арга барилд сургалгүйгээр дунд сургууль төгсгөдөг. Сурах бичигт арай нарийн ажиглалт хийж үзвэл, манай зохиогчдын сурах бичигт хураангуйлж бичих хэмжээний, хураангуйлах бололцоотой эх бичвэрийн төрөл жанр алга байна уу даа. Тиймээс юугаа ч хураангуйлах вэ дээ. Иймээс багшийг заасангүй, суралцагчдыг сурсангүй гэх арга алга байна даа. Харин сурах ёстойгоо заалгуулаагүй, иймээс сураагүй төгсөхөөс өөр яах ч юм билээ дээ.

**6. Санаагаа** гадаад хэлээр **хураангуйлах**: (“хэл оруулах”) Харин эх хэлээрээ эмхэлж цэгцэлж хураангуйлснаа одоо гадаад хэлээрээ хураангуйлж сургах нь, бидний бодоход, ёстой л уншаад олсон, ойлгосон, өөрийн болгосон **санаа**-ндаа, хэлэх-бичих **санаа**-тай болсондоо хэл оруулж, гадаад хэлд орж байгаагийн баталгаа, нотолгоо гэхээс өөр юу гэх билээ дээ. Харин гадаад хэлээр **товчлол** хийх гээд бүр толгой эхгүй болгоод орхидог тал ч байна. Иймээс тийм ч оновчтой хэлбэр биш, харин ч тоогоо алдсан, хөл толгой нь олохгүй, хөг ая нь алдарсан хэдэн гадаад үг, хөл толгойгоо цавчуулсан, ёстой л хөл толгойгоо гэсэн **“морь унасан толгойгүй хүн”** гэдэг шиг юм болдог шүү дээ. Товчлол биш, харин “тасдалт” болдог. Яагаад гэвэл юу товчилж байгаагаа мэддэггүй, “тас тас татаад”, хуулаад хуулаад бичихдэг. Бичсэн нь л үнэн болохоос, бичсэнээ ойлгосон нь бараг үгүй байдаг гэж болно доо. Учир юу вэ гэвэл, ойлгоогүй байхад нь энэ даалгаварыг хийж гүйцэтгэх үүрэг өгсөнтэй л холбоотой. Гэтэл гадаад хэлээр товчилж, аль эсвэл хураангуйлж сурсан байхын тулд юу товчлох, юу хураангуйлахаа мэдсэн, мэдэрсэн байх явдал чухал байдаг. Иймээс эх хэлээрээ мэдсэн, мэдэрсэн байж түүндээ хэл оруулах, гадаад хэл оруулах гэдэг хамгийн чухал баримтлах чиглэл юм шиг санагдах юм. Тус их сургуулийн сэтгэл судлал, нийгмийн ажил, боловсрол судлалын салбарт элсэгчдийн дунд сургуулиар олж авсан гадаад хэлний бэлтгэлийн түвшин, тэдэнтэй хамтарч ажилласан, хамтарч сурсан хэд гурван жилийн туршлагаас ажиглавал, цаашид анхаарч анзаарууштай хэд гурван бөл санаа байж болохоор байгаа юм. Үүнд:

**1.** Суралцагчдыг бичвэр дээр ажиллуулах үед уншуулаад, голдуу л яриулдаг, түүнд нь ч дүн, үнэлгээ голдуу тооцдог. Гэтэл тэд ойлгосноо ярих гэхээсээ илүү, ойлгож хүч хүрээгүй



учраас л тогтоож, цээжилж “ярьдаг” байна. Суралцагчид механикаар шахуу уншиж, автоматаар шахуу тогтоож, зөвхөн бичвэрийн агуулгаар дүн үнэлгээ тооцуулж явсаар дараа шатны сургуульд элсдэг аж. Унших техник, ойлгож унших буюу уншиж байхдаа хэлний дидактик нэгжүүдээ таньж мэдрэх, ухаарах зэрэг үйл явцын тал нь орхигдож, нэг үгээр хэлбэл, уншихуйд суралцах үр ухааны тал нь дан ганц суралцагчдад тохогож, дунд сургуульд суралцах бүхий л хугацааны туршид аргагүйн удирдлага үгүй шахуу урсгалаар явж иржээ. Харин эх бичвэрийг **сунгаж** үзэх болсноор богино богинохон эх бичвэр тогтоож дүн үнэлгээ тооцуулж ирсэн өмнөх аргаар **хуурч дийлэх, сурч хүч хүрэх аргагүй** болж ирж байгаа юм. Иймээс оюутан суралцагчдын дийлэнх хэсэг уншиж байгаа бичвэрийнхээ **хэлд орох** биш, бичвэрийнхээ **хэлнээс** бүр ч **дайжих** дээрээ тулаад байгаа учраас л эмзэглэхээр барахгүй, бүр эмлэмээр санагдаад байх юм. Сэтгэхүй-танин мэдэхүйн хийгээд хүмүүжил, боловсрол олгох үнэ цэнтэй сургалтын хэрэглэгдэхүүн болох сургах бичвэрийг яриулах, цээжлүүлэх, тогтоолгох гэж уваа алдан “улайрах” биш, харин уншиж байхдаа ойлгодог байх сургалтын стратегиар суралцагчдыг “бүрэн зэвсэглэсэн” байх (“уншихаа мэдэрдэг, утгаа мэдэрдэг байх, бүтэц-байгууламжаа мэдэрдэг байх”) дайны бүтээлч аргазүй эзэмшүүлэх шаардлагатай яах аргагүй нүүр тулгарч байна.

**2.** Хэлний төрөл бүрийн салбар хоорондын интеграцчиллын үр дүнд гадаад хэлний сургалтын олон салангид дидактик нэгжүүд шүтэлцэн багцрах, ойртон нягтрах, наалдан барьцалдах үйл явц хүчтэй явагдаж байна. Үгийн сангийн сургахзүйн нэгж дан үг байснаасаа хальж, хамжаа хэллэг (collocations or word partnerships), багцарсан хэллэг (institutionalized or fixed expressions), малгай өгүүлбэр (sentence frames or heads) болж томсов. Хэлзүй, өгүүлбэрзүйн дагнасан салангид айнууд хэлний дээд түвшингийн нэгж болох эх бичвэр (text), уялдаат яриа (discourse), төрөлжсөн салбар, чиглэлийн зориулалттай эх бүтээлийн дээжис (a corpus of a text) болж мөн л томслоо. Ийнхүү эдгээр томссон, багцарсан дидактик нэгжүүдээр гадаад хэлний сургалтыг хэлний шинжлэх ухааны интеграцчиллын өнөөдрийн түвшинд хүргэж зохион байгуулах гэдэг орчин цагийн шаардлага, аль ч шатны сургуулийн гадаад хэлний сургалт-судалга-аргазүйн ажлын нэг бүхэл бүтэн чиглэл болон тавигдаж байна. Нэг талаас, гадаад хэлний сургалтын сургахзүйн нэгжүүд үлэмж багцарч, сургалтын хэрэглэгдэхүүний хэмжээ **сунгуу**, нөгөө талаас сургалтын агуулга салбар хоорондын шинжтэй болж **цогцорч** ирж байгааг тооцохгүй өнгөрч яаж болох билээ. Иймээс багш, сургагчид хэлзүй-өгүүлбэрзүйн түвшинд хэлзүйн салангид үзэгдлүүд (grammatical sentences)-ийг заадаг аргазүйгээ аль болох түргэн сольж, дискурсийн түвшин (grammatical discourse)-д томссон, шүтэлцэн багцарсан дидактик нэгжүүдээр гадаад хэлний сургалт явуулдаг аргазүйд суралцах бэлтгэл хангах нь нэн чухал зорилт болон тавигдаж байна.

**3.** Суралцагчдын бодот хэрэглээг эх бичвэрийн түвшинд тооцсон (**уншихаа мэдрэх, утгаа мэдрэх, хэлзүйн байгууламжаа мэдрэх, санаа мэдрэх** зэрэг) даалгварууд дээр суралцагчдыг ажиллуулснаар тэдний сонирхол, оролцоо, идэвх, санаачилга үе үе өрнөөд алга болох биш, харин ч үлэмж **тогтворжиж**, багшаас авч байгаа үйлчилгээ, түүний хичээл хөтлөн явуулж буй аргазүйд (утгыг “оршуулдаг” биш, харин **орчуулдаг**, санаагаа “нурсадаг” биш, харин **хураангуйлдаг**, санаандаа санаснаараа гадаад хэл **оруулдаг**, бичвэрийг “огтлодог” биш, харин **товчилдог**, эхийг “хөглөөдөг” биш, харин **хөг оруулдаг** зэрэг гадаад хэлд суралцах үр дүнтэй арга барил эзэмшүүлж байгаа зэрэгт) хэрэглэгчид-үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр (96%) байна гэж сургуулийн сургалтын албанаас 2008-2009 оны хичээлийн жилийн эцсээр оюутнуудын дунд явуулсан санал асуулгын дүнгээр тогтоосон байх юм. Иймээс гадаад хэлний сургалтын агуулга-аргазүйн өгөөж, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд мэргэжлийн тэнхим, сургалтын тодорхой нэгж дээр туршилт судалгааны энэ мэт ажлын эхлэл, үүсгэл санаачилгыг цаашид хөхүүлэн дэмжиж хэд хэдэн салбар, мэргэшлийн чиглэлийг хамруулан, бүрэлдэхүүнийг өргөжүүлэн, баг, төслийн хэлбэрээр зохион байгуулахад ч тэр, бас зориуд анхаарч санхүүгийн тодорхой эх үүсвэр гаргаж дэмжлэг үзүүлэхэд ч тэр, харамлах, хатуурхах, халгах, бэргэх зүйл юун.

**4.** Яаж уншуулах, унших үйл явцыг яаж хөтлөх вэ гэдэг асуудлын хажуугаар эх бичвэрийн “гаралт” судалж байгаа хэл дээр байх уу, аль эсвэл төрөлх эх хэл дээр байх уу гэдэг бас ч эргэж харууштай асуудал болж байгаа юм. Гадаад хэлээр мэргэших салбарын зориулалт чиглэлтэй, хийсвэр үг хэллэг, ойлголт давамгайлсан, өгүүлбэрзүйн байгууламж нарийн нийлмэл, үлэмж урт эх бичвэр ажиллаад гаралтыг гадаад хэлээр биш, харин эх хэлээрээ хүлээн авдаг байх нь ч зөв байж мэдэх юм. Гадаад хэлээр эх бичвэр уншиж **ойлгосны** хамгийн найдвартай баталгаа, шалгуур бол, нэг талаас эх хэлээрээ товчлох, хураангуйлах, тэр ч байтугай эх хэлээр нь яриулах явдал гэж төрөлх хэлтэн судлаачдын үлэмж хэсэг үзэх болсон, нөгөө талаас, манай суралцагчид гадаад хэлээр уншиж ойлгосон мэдээллээ эх, төрөлх хэлээрээ ашиглах хэрэглээ өндөр байдагтай ч холбоотой байгаа юм. Суралцагчдын эх, төрөлх хэлэнд нь ухамсартай тулгуурлах харилцааны зарчмыг бид баримтлах гэж хичээдэг байвал зохино. Эх хэлнээс нь эрхэм шавь нараа эргүүлж чангаа ямар ч хэрэг байхгүй. Насанд хүрсэн алив хүн гадаад хэлээр уншаад, эсвэл сонсоод эндүүрсэн болгоноо эх сайхан хэлээрээ эргэцүүлэн ойлгож ухаарч байдаг хорвоогийн жам байдаг ажгуу. Иймээс дунд сургуульд эх хэлээрээ уншиж сурахдаа хуримтлуулсан бага боловч **“мэдрэмжийн туршлага”** (Хишигт Я.)-ыг бараг ашиглахгүйгээр, гадаад хэлээр унших төдийгүй, ойлгож унших стратеги, ойлгож байж хэлд орох арга барилд суралцуулахгүйгээр суралцагчдаа төгсгөж үдээд байж болмоор байна гэжүү!

## НОМЗҮЙ

- Жадамба Б. Шүтэлцэн багцрахуйн үзэл ба хүмүүний хөгжил.Уб., 2008.
- Хишигт Я. Хүн-мэдрэмжийн тухай аж онолын үндэс (Аж амьдрал, оновчтой сургалт, шинэлэг судалгааны асуудлууд), Уб., 1999.
- Хишигт Я, Энхтөгс Х. Боловсролын аж асуудлууд: Гадаад хэлний сургалтанд эх, оригинал захиолыг шууд ашиглах, оюуны экспорт хийх чадварыг эрс нэмэгдүүлэх аж онолын асуудлууд. Уб., 2007.74-105 тал;
- Нямжав Д. Орос хэлний сургалтын сэтгэлзүйн зарим асуудал. Уб., 2002.
- Базаррагчаа М. Монгол хэлний өгүүлбэр судлал. Уб., 2005.
- Пүрэв - Очир Б. Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй Эх задлалын асуудлууд, 4-р дэвтэр, Уб., 2002/2005.
- Даваабаяр Ц. Их дээд сургуулиар олгох гадад хэлний боловсролын хүртээмжийг дээшлүүлэх агуулга-аргазүйн асуудалд. ГХЗАА сэтгүүл, 2009, №21, 51-55 тал; "Оюуны Хөтөч" сэтгүүл, №4, 57-64 тал;
- Даваабаяр Ц. Уншиж байж хэл олдог, ойлгож байж хэлд ордог. ГХЗАА сэтгүүл, 2009. №22.
- Цэдэв Х. Гадаад хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх боломж, эргэцүүлэл: ГХЗАА, №2, 2002, 35-37 тал;
- Дариймаа М. Гадаад хэл сурч байгаа оюутнуудын уншиж ойлгох чадварыг хөгжүүлэх асуудалд: ГХЗАА сэтгүүл, №9, 2006, 55-56 тал;
- Дэлгэрмаа О. Орос хэлний сургалтын хэрэгцээ ба бид: ГХЗАА, 2002, №2, 48-49 тал.
- Цэцэгмаа Ц. Гадаад хэлний сургалт, сурах бичгийн асуудалд: Оюуны Хөтөч сэтгүүл, №4, 2009, 98-105 дахь тал.
- Батчулуун Д. Хэлний хэмнэл, элбэгшил, ойртол ба мэдээллийн багтаамж: ГХЗАА, №3,28-31 тал.
- Ганчимэг З. Шинжлэх Ухааны хялбаршуулсан дискурсийг когнитив хэл шинжлэлийн үүднээс зэрэгүүлэн судлах нь /монгол, англи, орос хэлний хэрэглэгдэхүүн дээр/, Дисс., 2003.ГанчимэгЗ.: Дискурсийг гадаад хэлний сургалтад хэрэглэх аргазүй: ГХЗАА сэтгүүл, 2004, №5, 57-59 дахь тал.
- Амаржаргал Н. Англи хэлний сургалтад хэрэглэх унших эх сурвалж: ГХЗАА сэтгүүл, 2004, №4, 60-63 дахь тал.
- Дэмид Б. Гадаад хэлний сургалтын аргазүйн улмжлал шинжлэлийн асуудалд. Гадаад хэл заах аргазүйн асуудал сэтгүүл, №17, 2008, 33-35 дахь тал.
- Дэмид Б. Текстэнд тулгуурлан гадаад хэлний сургалтын аргазүйг боловсронгуй болгох нь: дэд эрдэмтний зэрэг хамгаалсан бүтээл.Уб. 1998.
- Алтанцэцэг Д. Орос хэлээр мэргэжлийн эх хураангуйлах аргазүйн зарим асуудал: ГХЗАА, №8, 2005, 92-94 тал;
- Алтанцэцэг Д. Оюутны мэргэжлийн эх хураангуйлах үйл ажиллагаанд хийсэн судалгаанаас: МУБИС байгуулагдсаны 55 жилийн ойд зориулсан тусгай дугаар, Гадаад хэлний Сургуулийн Эрдэм Шинжилгээний Бичиг, Уб., 2006, 117-121 тал.
- Krashen, S. D. 1982. Principles and practice in second language acquisition.Oxford, England: Pergamon.Brown, H.D.2000. Principles of Language Learning and teaching, 4<sup>th</sup> ed. Longman: Pearson Education NY.
- H.Douglas Brown 2001.Teaching by Principles.San Francisco University.
- Levis, M.1993. The lexical approach.Hove, UK: Lanhuage Teaching Publications.
- Levis, M.1996.Implications of a lexical view of Language in J.and D.Willis Challenge and Change in Language Teaching. Oxford: Heinemann.
- Hughes, A.2003.Testing for Language teachers. 2-nd ed. Cambridge: Cambridge University Press.
- Nuttall, C.1982.Teaching reading skills in a foreign Language.London: Heinemann.